



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 185


Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 онд Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулах захиалагчийн эрхийг шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.
3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 950

05 Аймгийн Засаг даргын 2017 оны
дугаар сарын өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мян.төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих дүн
1	Хэрлэн сумын гудамжны гэрэлтүүлэг	2017 он	20 000,0	20 000,0

Аймгийн Засаг даргын 2017 оны 05
дугаар сарын 11 өдрийн 01/185 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мян.төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих дүн
1	Эрүүл мэнд хөдөлгөөн хөгжил дэд хөтөлбөр	2017 он	25 000,0	25 000,0